



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

/Дунд хугацааны бодлогын баримт бичиг 2022 -2024 он /

**Дархан-Уул аймаг
2022 он**

БҮТЭЦ, АГУУЛГА

НЭГ. Нийтлэг үндэслэл;

ХОЁР. Мандатын шинжилгээ;

ГУРАВ. Алсын хараа;

ДӨРӨВ. Эрхэм зорилго, Үнэт зүйлс;

ТАВ. Орчны шинжилгээ;

ЗУРГАА. Стратегийн зорилго;

ДОЛОО. Шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги;

НАЙМ. Стратеги зорилго ба байгууллагын бүтцийн уялдаа;

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Сүүлийн жилүүдэд соёл, урлагийн салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлогын гол үзэл баримтлал нь үндэсний соёлыг дэлхийн соёлын шилдэг ололттой хослуулан хөгжүүлэх, нүүдэлчдийн язгуур өв соёл, үнэт зүйлсийг дэлхий дахинд сурталчлан таниулах, үзвэр, үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгох, соёл, урлагийн салбарт өмчийн олон хэлбэрийг бий болгож, уран бүтээлчдийн бүтээн туурвих эрх чөлөөг бүх талаар хангах, соёлын ажилтан, уран бүтээлчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хүн амын соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын хандив тусламжийг нэмэгдүүлэх, салбарын хяналт шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Соёлын салбарын хөгжлийг шинэ шатанд хүргэхэд одоогийн нөхцөл байдлыг бодитой судлан хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн залгамж чанарыг хадгалан, үйл ажиллагаагаа орчин үеийн дэвшилтэт технологид тулгуурлан эрчимжүүлэх, соёл, урлагийн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дунд хугацааны стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Дархан-Уул аймгийн соёл, урлагийн салбарын 2022-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг удирдамж болгон боловсруулав.

Дархан-Уул аймгийн соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн үндэс нь “Алсын хараа-2050”, “Соёлын яамны стратеги төлөвлөгөө 2021-2024, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУЗГ-аас Дархан-Уул аймгийг төвийн бүсийн тулгуур төв аж үйлдвэр мэдээлэл технологийн загвар хотоор хөгжүүлэх төлөвлөгөө, аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүд бөгөөд энэхүү стратегийн баримт бичиг нь аймгийн цаашдын соёл, урлагийн салбарын алсын хараа, эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, зорилтуудыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд удирдамж болох юм.

Эдүгээ өнөөгийн нийгэмд хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн, өрсөлдөөнд суурилсан соёл урлагийн хүртээмжтэй олон талт үйлчилгээг нийгэмд хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий, тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай орон нутгийн онцлог шинжийг харуулсан соёл, урлагийн үйлчилгээний тогтолцоо, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэх, соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах найдвартай тогтолцоог бүрдүүлэхэд орон нутгийн онцлогыг тусгасан бодлого зайлшгүй хэрэгтэй юм.

1.2 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ҮНДСЭН ЗАРЧМУУД

Стратеги төлөвлөгөө боловсруулахдаа салбарын мэргэжилтэн, судлаачдын мэдлэг ур чадварыг нэгтгэн уялдуулах, соёл урлагийн менежмент, маркетингийн орчин үеийн шинэлэг зарчим, арга барилд тулгуурлах, дэлхийн тэргүүлэх театр урлагийн байгууллагын НОУ-ХАУ дэвшилтэт технологийг салбарын үйл ажиллагаа, үйлчилгээнд нэвтрүүлэх, мөн санхүүжилт нь үр дүнгийн биелэлттэйгээ нийцсэн тодорхой уялдаатай байх үндсэн зарчимд үндэслэв.

Энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулахад Үндэсний, язгуур эрх ашигт нийцсэн байх, нэгдмэл цогц харилцан уялдаатай байх, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх, судалгаа шинжилгээнд үндэслэсэн, нөөц бололцоонд тулгуурласан байх, ил тод, нийгмийн түншлэлийн зарчимд суурилсан байх, үндсэн зарчмуудыг баримтлав.

Төлөвлөгөөний зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхойлох түүнийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:

- Төлөвлөлт нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, тогтоомж болон бусад холбогдох бодлогын баримт бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх;
- Төлөвлөлт нь олон улсын хөгжлийн чиг хандлага, үндэсний онцлогт нийцсэн байх;
- Хэнийг ч орхигдуулахгүй бүх нийт, хувь хүн, хамт олон, нийгмийн бүлгүүдийн амьдралыг өөрчлөн сайжруулах, хүрч үйлчлэхэд чиглэсэн, соёлын харилцаанд оролцогчийг соёл урлагийг хүртэх, эзэмших, мэргэжил ур чадвараа дээшлүүлэх, адил тэгш боломжоор хангасан;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллага, удирдах ажилтнууд болон багш, ажилтнуудын хүсэл эрмэлзэл, тэдний хоорондын харилцан итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурлах;
- Төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо, иргэд, гадаадын хандивлагч, сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэх;
- Төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт нь институцэд суурилсан байх зэрэг болно.

1.3 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөлтийн үндсэн зарчим, арга зүй, системийн хандлагад үндэслэн дор дурдсан шат дарааллыг баримталсан болно. Үүнд:

- Стратеги төлөвлөлтийн баг бүрдүүлэх, ажлын төлөвлөгөө боловсруулж мөрдөх, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Салбарын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, цогц судалгаа шинжилгээний арга зүй боловсруулах, хамрах хүрээг тодорхойлох;
- Үзвэр үйлчилгээ, уран бүтээлийн чанарыг тодорхойлох, үзэгчдийн сэтгэл ханамж, хэрэгцээг үнэлэх, тандалт судалгаа авч дүн шинжилгээ хийх;
- Салбарын өнөөгийн хүний нөөцийн ур чадварын түвшинг үнэлэх, цаашид хөгжлийн зорилго, зорилтыг хангах ур чадварыг тодорхойлох судалгаа авч дүн шинжилгээ хийх
- Хөгжлийн зорилго, зорилтуудад хүрэх арга зам, стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөх;
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тодорхойлж үнэлэх;
- Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тулгарч болзошгүй эрсдэлүүдийг тогтоох

- Стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжих зорилго бүхий шаардлагатай зорилтот хөтөлбөрийг тодорхойлох;

Энэхүү стратеги төлөвлөгөөний гол агуулга нь соёл, урлагийн байгууллагууд нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан өөрийн үйл ажиллагааны хүрээнд бодитой хувь нэмэр оруулж, байр сууриа бэхжүүлэн хөгжүүлэхэд оршиж байна.

Энэ нь соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд иргэдийн соёл, урлагийн боловсрол дээшлүүлэх, уран бүтээл туурвих, үндэсний соёл уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, үзвэр үйлчилгээг сайжруулах, бүтээлч орчин бий болгох зэрэг үйл ажиллагааныхаа чанар хүртээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодит боломжийг бүрдүүлж, түүнийг үр ашигтай, оновчтой ашиглах менежментийг хэрэгжүүлэхэд чиглэгдэх бөгөөд стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх гол нөхцөл болно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралт “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг ашиглан тухайн байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээгээр хууль тогтоомжоос соёл, урлагийн салбарын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох, тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах, салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох, чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох мандатын шинжилгээ хийж, алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлох ажлын хүрээг тогтоолоо.

Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- “Чиг үүрэг” гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэлийг;
- “Чиг үүргийн шинжилгээ” гэж хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид төрийн байгууллагын чиг үүргийг хэрхэн тогтоосон, түүнд хамаарах эрх зүйн орчин болон бодлого стратеги, хөтөлбөр, бүтэц зохион байгуулалт, төсөв, зардалд зохих арга зүй ашиглан иж бүрэн дүн шинжилгээ хийхийг;
- “Ерөнхий чиг үүрэг” гэж тухайн салбарын эрхлэх асуудлын хүрээг;
- “Үндсэн чиг үүрэг” гэж тухайн ерөнхий чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны тодорхой чиглэлийг;
- “Дэд чиг үүрэг” гэж тухайн үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны нарийвчилсан чиглэлийг;
- “Захиргааны эрх хэмжээ” гэж тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн бодлого боловсруулах, зохицуулах, зохион байгуулах, санхүүжүүлэх, үйлчилгээ үзүүлэх, хүний нөөцийн бодлого болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлийн эрх хэмжээг;

2.1 СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1.1 Монгол Улсын хуулиуд

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хуулийн тоо: 39		
Тухайн салбарын хуулийн тоо: 16	1	Монгол улсын Үндсэн хууль;
	2	Соёлын тухай;
	3	Соёлын өвийг хамгаалах тухай;
	4	Номын сангийн тухай;
	5	Музейн тухай;
	6	Монгол хэлний тухай;
	7	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай;
	8	Кино урлагийг дэмжих тухай хууль;
	9	Төр, сүм хийдийн харилцааны тухай;
	10	Байгууллагын нууцын тухай;
	11	Оюуны өмчийн тухай;
	12	Патентийн тухай;
	13	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиуд
	14	Эрдэнэсийн сангийн тухай;
	15	Садар самуун явдалтай тэмцэх тухай;
	16	Зар сурталчилгааны тухай;
Үүнээс:		
Нийтлэг мөрддөг хуулийн тоо - 23	1	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай;
	2	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай;
	3	Төрийн албаны тухай хууль;
	4	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай;
	5	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай
	6	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай;
	7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай;
	8	Авлигын эсрэг хууль;
	9	Төрийн хяналт шалгалтын тухай;
	10	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай
	11	Төсвийн тухай;
	12	Нягтлан бодох бүртгэлийн тухай;
	11	Шилэн дансны тухай;
	12	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай;
	13	Хөдөлмөрийн тухай;
	14	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай;
	15	Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль
	16	Захиргааны ерөнхий хууль;
	17	Эрүүгийн хууль;
	18	Зөрчлийн тухай хууль;
19	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай;	
20	Инновацийн тухай;	

	21	Хаягжуулалтын тухай;
	22	Галын аюулгүй байдлын тухай;
	23	Барилгын тухай хууль;

2.1.2 Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг

№	Зарлиг	Огноо	Дугаар
1	Үндэсний бичиг үсгийн баяр тэмдэглэх тухай	2003.06.25	105
2	Номын баярын өдөр тэмдэглэх тухай	2012.08.24	158
3	Монголын нууц товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай	2004.02.18	23

2.1.3 Улсын Их хурлын тогтоол

№	Тогтоолын нэр	Огноо	Дугаар
1	Төрөөс соёлын талаар баримтлах бодлого	2012	№52
2	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай	2020	№ 25
3	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай	2020	№ 23
4	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	2020	№ 45
5	“Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”	2020	№ 23

2.1.3 Монгол Улсын Засгийн газрын тогтоол

№	Тогтоолын нэр	Огноо	Дугаар
1	Соёл, урлагийн сан байгуулах тухай	1998	№40
2	Олон Улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох журам	2003	№ 227
3	“Хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журам”	2006	№ 115
4	Угийн бичиг хөтлөх журам	2007	№ 257
5	Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам	2007	№ 280
6	“Шилдэг уран бүтээлч шалгаруулах журам”	2008	№ 195
7	Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт батлах тухай	2013	№227
8	“Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр батлах тухай	2015	№ 509
9	Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам	2016	№52
10	“Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам”	2016	№288
11	“Сонгодог урлаг-III” үндэсний хөтөлбөр батлах тухай	2018	№ 141
12	Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай	2018	№ 263

13	Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам	2018	№184
14	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам	2018	№184/1
15	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам	2018	№184/2
16	Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам	2018	№354
17	“Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам батлах тухай”	2019	№ 25
18	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм	2019	№ 33
19	“Соёлын биет бус өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөр	2019	№68
20	“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр	2019	№69
21	“Б.Шаравын нэрэмжит мэргэжлийн дуучид, үндэсний хөгжимчдийн олон улсын уралдааныг 2020 оноос 4 жил тутамд зохион байгуулах тухай”	2019	№143
22	Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай	2019	№475
23	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай	2020	№13
24	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам	2020	№206
25	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам	2020	№ 217
26	Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай	2021	№ 179
27	Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай	2021	№377
28	Кино бүтээх зардлын буцаан олголтын хүсэлт гаргах, төслийг хянах, бүртгэх, гэрээ байгуулах, үнэлэх, тайлагнах, зардлын тодорхой хувийг буцаан олгох журам	2022	№133
29	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2022	№07
30	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын Зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам	2022	№291
31	Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн Тэргүүлэх чиглэл (2022-2027)	2022	№314/1
32	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ (2022-2032 он)	2022	№314/2
33	Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай Хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад Бүртгэх журам	2022	№392

2.1.4 Олон улсын конвенци:

№	Шийдвэрийн нэр		Он
1	Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр оруулах, гаргах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц	ЮНЕСКО,	1970
2	Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай	ЮНЕСКО,	1972
3	Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц	ЮНЕСКО,	2003
4	Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай	ЮНЕСКО,	2005

2.1.5 Сайдын тушаал:

Соёлын салбарын хүрээнд:		Огноо	Дугаар
1	Соёл, урлагийн сан байгуулах тухай	1998	№ 40
2	Сангийн сайдын “Төсвийн зарлагын хэмнэлт үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”	2019	№ 74
3	Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон яамны шагнал олгох журам	2020	A/05
4	Орон нутгийн өмчит соёл, урлагийн байгууллагуудын дарга, захирлын албан тушаалын тодорхойлолт батлах тухай	2020	A/75
5	Кино түгээлтийн мэдээлэл гаргах журам	2022	A/199
Мэргэжлийн урлагийн байгууллага:			
1	Мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм	2015	№A/495
Музей:			
1	Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар	1999	№1384
2	Монгол улсын музейн сан хөмрөгийн дүрэм	2005	№347
3	Улс, орон нутгийн музейн дүрэм	2009	№98
4	Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар батлах тухай	2012	A/355
5	Түүх, соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам /Сангийн сайдын/	2013	140
6	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам /БСШУС, Сангийн сайдын хамтарсан/	2019	237/92
7	Нийслэл, аймгийн хамгаалалтад авах дурсгалын жагсаалт батлах тухай	2020	A/161
8	Музейн олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм батлах тухай	2022	A/210
Номын сан:			
	Номын сангийн данс, маягт шинэчлэн батлах тухай	2005	№414

1	“Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах журам		
2	Ном, хэвлэлийг дахин үнэлэх журмыг шинэчлэн батлах тухай	2007	№414
3	Аймаг, нийслэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм	2007	№414
4	Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх журам /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын/	2018	A/821
5	Алдагдсан буюу гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэх журам	2007	№415
6	Сумдын номын санг ном хэвлэлээр хангах аргачлал	2008	№85
7	“Номын сангийн үйлчилгээг автоматжуулахад баримтлах зөвлөмж”	2009	№563
8	Номын сан хооронд ном солилцоо хийх үйл ажиллагаанд баримтлах зөвлөмж	2010	№550
10	Уншлагыг дэмжих журам	2018	№683
Соёлын төв			
1	Соёлын төвийн дүрэм	2011	A/83

2.1.6 Монгол Улсын стандартууд:

№	№ Стандартын нэр	Огноо	Дугаар
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, цахилгааны аюулгүй ажиллагаа	2002	MNS 5151 : 2002
2	Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	2014	MNS 6476: 2014
3	Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	2014	MNS 6476: 2014
4	Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавих шаардлага	2016	MNS: 5634: (2006)
5	Ном зүйн бичилт	2012	MNS 5271:2012
6	Аудио видео материалын ном зүйн бичилт	2012	MNS 5638:2012
7	Нотны хэвлэлийн ном зүйн бичилт	2012	MNS 5639:2012
8	Газрын зургийн хэвлэл, бүтээлийн ном зүйн бичилт	2012	MNS 6334:2012
9	Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага	2019	MNS 5742:2019
10	Мэдээлэл ба баримтжуулалт, архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага	2019	MNS ISO 11799:2019
11	Соёлын төв, соёлын ордон. Орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага стандарт	2022	MNS 6981:2022

2.1.7 Аймгийн ИТХ-ын тогтоол

№	Шийдвэрийн нэр	огноо	дугаар
---	----------------	-------	--------

1	Дархан-Уул аймгийн 2021-2025 он хүртэл хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай	2020	2/07
2	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	2020	2/08
3	Дархан-Уул аймгийн 2022 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө	2021	10
4	“Оюунлаг Дархан” дэд хөтөлбөр батлах тухай	2021	61

2.1.8 Аймгийн Засаг даргын захирамж

№	Шийдвэрийн нэр	огноо	дугаар
1	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	2021	01- А/132

2.2 ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖООС СОЁЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМААРАХ ЧИГ ҮҮРЭГ ОРОЛЦОГЧ ТАЛЫГ ТОДОРХОЙЛОХ;

Салбарын мандат нь бодлогын болон эрх зүйн баримт бичиг, хөтөлбөрүүдэд тодорхойлогдсон, мөн холбогдогч талуудын өмнө байгууллагын хүлээж буй бусад үүрэг, хариуцлага юм. Төрийн байгууллагын хувьд мандат нь салбарын чиг үүргийг тодорхойлоод зогсохгүй, холбогдогч талуудаас хүлээж буй үр дүнг тогтоож өгсөн бөгөөд стратегийн зорилго, зорилтыг хангахын тулд өөрт байгаа боломжид тулгуурлан ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой, мөн үйл ажиллагаанд нь ямар хязгаарлалт байгааг таньж мэдэх боломж бүрдэнэ.

Соёлын салбарын захиргааны эрх хэмжээ буюу хуулиар тогтоож өгсөн эрх хэмжээний хүрээнд 39 хуулийн холбогдох заалтуудад дүн шинжилгээ хийсэн бөгөөд мандатын шинжилгээний үр дүнд 1 ерөнхий чиг үүрэг, 8 үндсэн чиг үүрэг, 2 нийтлэг чиг үүрэг, 21 дэд чиг үүргийг тодорхойлов.

Нийт хуулийн тоо 39	Тухайн салбарын хуулийн тоо -16	
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо - 23	
Ерөнхий чиг үүрэг-1 Төрөөс соёлын салбарт баримталж буй соёл, урлагийн салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1.Соёлын өв	Түүхэн дурсгалт барилга байгууламж, музейн үйлчилгээ	Аймгийн СУГ, аймгийн Музей, Сумдын ЗДТГ сүм хийд,
	Сумдын орон нутаг судлах танхимын үйлчилгээний чанар, хүртээмж	Аймгийн СУГ, Соёлын төв, Музей сумдын ЗДТГ
	Түүх археологийн дурсгалт газрын үйл ажиллагаа	Аймгийн ЗДТГ, СУГ, БОАЖГ
2. Соёлын биет бус өв	Биет бус өвийг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах, бүртгэл мэдээллийг сайжруулах	Аймгийн Музей, Сумдын соёлын төвүүд, Өвлөн уламжлагчид
	Театр, урлагийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж	Аймгийн ЗДТГ, СУГ, Залуучууд театр

3.Урлаг, соёлын үйлчилгээ, Уран бүтээлийн тоглолт	Сумдын соёлын төвийн үзвэр, үйлчилгээний чанар, хүртээмж	Аймгийн СУГ, Сумдын ЗДТГ, Соёлын төв
	Гадна талбайн тоглолт, арга хэмжээ /Тэмдэглэлт өдрүүд, баяр наадам, эвэнт, шоу/	Аймгийн ЗДТГ, СУГ, Залуучууд театр, Сумдын ЗДТГ, Соёлын төв
4.Утга зохиол, ном хэвлэл	Утга, уран зохиолын бодлого, үйл ажиллагаа	Аймгийн ЗДТГ, СУГ, МЗЭ -ийн салбар зөвлөл, зохиолч, сэтгүүлчид
	Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмж	Аймгийн ЗДТГ, СУГ, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Сумдын Соёлын төвийн номын сан, Их, дээд, ЕБСургуулийн номын сан,
	Хэвлэн нийтлэлийн бодлого, үйл ажиллагаа	Аймгийн СУГ, хэвлэлийн үйлдвэр, цех
5. Бүх нийтийн соёлын боловсрол	Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, СУГ, БШУГ, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Сумдын Соёлын төвийн номын сан, Их, дээд, ЕБСургуулийн номын сан,
	Угийн бичиг хөтлөх, уламжлалыг сэргээх	Аймгийн ЗДТГ, СУГ, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Сумдын Соёлын төвийн номын сан, Их, дээд, ЕБСургуулийн номын сан,
	Соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагаа	Аймгийн ЗДТГ, СУГ, БШУГ, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Сумдын Соёлын төвийн номын сан, Их, дээд, ЕБСургуулийн номын сан,
6.Уран зураг, дүрслэх урлаг, гар урлал	Уран зураг, уран баримал	Аймгийн ЗДТГ, СУГ, Дарханы Зураач урчуудын эвлэл
	Дизайны бодлого, үйл ажиллагаа	Дизайнерууд
	Дижитал арт, реклам, зар сурталчилгаа Телевиз, радио	Аймгийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Гудамжны самбаруудыг эзэмшигчид, Телевиз, радио
	Гар урлалын бодлого, үйл ажиллагаа	Аймгийн ЗДТГ, СУГ, ЖДҮ - ийн төв, мужаан оёдлын цех зэрэг
7.Хэвлэл мэдээлэл, кино дуу дүрсний урлаг	Телевиз, радио, мэдээлэл сурталчилгаа	Аймгийн СУГ, Харилцаа холбооны зохицуулах газар, орон нутгийн ТВ, Радио
	Кино үзвэр	Аймгийн СУГ, Кино театр, үзвэрийн цэг, соёлын төвүүд

8.Нийтлэг хамааралтай чиг үүрэг	Хүний нөөц	Аймгийн ЗДТГ, СУГ, соёлын байгууллагууд
	Гадаад хамтын ажиллагаа, түншлэл	СУИС, МУК

2.3 ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Соёлын салбарын статистик 2021 он, салбарын өнөөгийн байдал



2.3.1 СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГА:

/2021 оны суурь түвшин/

№	Байгууллагын нөөц	Тоогоор	
1	Мэргэжлийн урлагийн байгууллага /Залуучууд театр/	1	
2	Төв номын сан	Төв номын сан	1
		Салбар номын сан	1
		Архив	1
3	Хүүхдийн номын ордон	1	
4	Аймгийн Музей	Музей	1
		Орон нутгийн судлах танхим	2
5	Сумдын соёлын төв	3	
	Нийт	5	
		12	

2.3.2 СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ:

/2021 оны суурь түвшин/

№	Нөөцийн нэр, төрөл	Хэмжих нэгж	Нөөцийн хэмжээ
Урын сангийн нөөц:			
1	Үндэсний дуурь тоо	тоо	2

2	Сонгодог жүжиг тоо	тоо	10
3	Хүүхдийн жүжиг тоо	тоо	11
4	Драмын жүжиг тоо	тоо	17
5	Бүжгийн жүжиг тоо	тоо	1
6	Концерт	тоо	25
Соёлын өвийн нөөц:			
1	Нийт үзмэр	тоо	1362
2	Хосгүй үнэт үзмэр	тоо	0
3	Түүх соёлын үл хөдлөх нийт дурсгал	тоо	53
4	Соёлын биет бус өвийн нийт өвлөн уламжлагч	тоо	74
Ном хэвлэлийн нөөц:			
1	Нийт сан хөмрөг тоо	тоо	79626
2	Уншигч тоо	тоо	121356
3	Ном олголт	тоо	51444
Соёл олон нийтийн ажил:			
1	Соёлын төвийн урын сан	тоо	38
2	Сонгон дугуйлан	тоо	12
3	Соёл олон түмний үзвэр үйлчилгээ	тоо	5450
4	Орон нутаг судлах танхимын нийт үзмэр	тоо	157

2.3.3 САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ:

/2021 оны суурь түвшин/

№	Албан хаагчдын тоо бүтцийн нэгжээр	Суурь түвшин
1	Захиргаа, аж ахуй	50
2	Мэргэжлийн ажиллагсад	50
2	Бусад ажилтан	56
	нийт	156

Их дээд сургууль төгссөн болон суралцаж буй боловсон хүчин судалгаа

/2021 оны суурь түвшин/

№	Боловсролын түвшин	Суурь түвшин
1	Дотоодын болон гадаадын их, дээд, сургууль	102
2	Техникум	31
3	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	6
4	Бүрэн дунд	15
5	Бүрэн бус дунд	2
	Нийт	156

2.3.4. САЛБАРЫН САНХҮҮГИЙН НӨӨЦ:

/2022 оны батлагдсан төсөв/

№	Нэгж	Тоо	Жилийн төсөв
1	Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Залуучууд Театр	1	1,540,776.30
2	Төв номын сан	1	277,679.80
3	Хүүхдийн номын ордон	1	149,685.90
4	Аймгийн Музей	1	281,833.60
5	Соёлын төв	3	521,454.30
	Нийт дүн	7	2,771,429.90

2.3.5. САЛБАРЫН АЖ АХУЙН ЧАДАВХ:

/2021 оны суурь түвшин/

№	Үндсэн хөрөнгө	Тоо хэмжээ	Мөнгөн дүн Мян.төг
1	Барилга байгууламж	10	7,366,562.4
2	Үүнээс соёлын зориулалттай	10	7,366,562.4
3	Хөгжмийн зэмсэг	294	119,172.4
4	Гэрэлтүүлэг тоног төхөөрөмж	1017	239,398.4
5	Дуу авианы тоног төхөөрөмж	316	248,390.4
6	Тавилга эд хогшил	2065.2	269,698.6
7	Тоног төхөөрөмж /компьютер/	246	156,473.4
8	Ном хэвлэл /сан хөмрөг/	72484	320,624.1
9	Биет бус хөрөнгө	13	11,895.2
10	Түүх соёлын дурсгалт зүйлс	1373	600,339.1
11	Тээврийн хэрэгсэл	4	134,905.0
	Нийт	77832.2	9467459.0

2.3.6. САЛБАРЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХҮЧИН ЧАДАЛ:

№	Хүчин чадал	Хэмжих нэгж	Дүн
1	Соёлын төв	Тоогоор	4
	Соёл, спортын цогцолбор	Тоогоор	2
	Музей, театр, номын сан	Тоогоор	3
2	Барилгын нийт талбай мк2 130.913.76	мк2	13,865.5
3	Барилгын нийт эзлэхүүн м3 807607.63	м3	90,890
4	Тоглолтын тайзны эзлэхүүн м3 105477603	м3	1,142
5	Тайзны тоо	Тоогоор	5
6	Соёлын байгууллагуудын суудлын тоо	Тоогоор	1488
7	Харааны хөгжлийн бэрхшээлтэй иргэд явах тусгай зам	Тоогоор	1
8	Тэргэнцэртэй иргэдийн налуу зам	Тоогоор	9

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Бүс нутгийн түүх, соёлын онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, үндэсний бахархал, эх хэл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, эх оронч, оюунлаг, бүтээлч монгол хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн төвийн бүсийн шилдэг соёл, урлагийн салбар байна.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол үндэсний болон дэлхийн сонгодог уран бүтээлийг мэргэжлийн өндөр түвшинд туурвих, иргэдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээнд судалгаа инновацийн үйл ажиллагааг эрчимжүүлж иргэдэд хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар соёл, урлагийн үйлчилгээг үзүүлэхэд чиглэнэ.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Соёл, урлагийн салбарын бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, хуулиар ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх боломж ямар байгааг гадаад ба дотоод орчны хүчин зүйлийн хүрээнд тулгуурлан дараах байдлаар тодорхойлов.

5.1 Дотоод орчны шинжилгээ: Дотоод орчны шинжилгээг хийхдээ салбарын бүтэц, зохион байгуулалт, соёл, нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл) хийгээд технологийн үйл явц зэрэг хүчин зүйлсийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойлов.

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Дархан-Уул аймаг нь төвийн бүсийн тулгуур төв, Үндсэн хуулинд хотын статустай, Аж үйлдвэр, мэдээллийн технологи бүхий хот. - Эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгаагаар улсад 4-р байр, ХХИ-ээр 3-р байрт эрэмлэгдсэн. - 104737 хүн амтай нийт хүн амын 67.9 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 15 хүртэлх насны хүүхэд 32.1 хувийг эзэлж байна. - Бие даасан яамтай болсон. - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, хамтран ажилладаг. - Төрөөс болон орон нутгаас сүүлийн жилүүдэд соёл урлагийн байгууллагуудыг анхаарч, дэмжлэг үзүүлж байна. 	<ul style="list-style-type: none"> - Менежментийн тогтолцоо төлөвшөөгүй. - Орон нутгийн соёл, урлагийн салбарын бүтэц тодорхой бус, зохион байгуулалт оновчгүй. - Чиг үүргийн уялдаа холбоо хангалтгүй. - Мэргэжлийн урлагийн байгууллага болон сумдын соёлын төвүүдэд мэргэжлийн хүний нөөц дутагдалтай. - Соёлын байгууллагуудын техник, тоног төхөөрөмж хоцрогдсон. - Хөгжмийн зэмсэг, урлагийн хувцас хэрэгсэл хуучирч элэгдсэн, хүрэлцээ муутай. - Албан хаагчдын нийгмийн баталгааг сайн хангаж ажиллаж чаддаггүй. - Чөлөөт уран бүтээлчид төрийн урлагийн бодлогийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн дэмжлэгийг хараахан авч чадаагүй байна. - Соёл, урлагийн байгууллагуудын жилийн төсвийн сумдад 30-50 хувь, төвд 4-12 хувь

<ul style="list-style-type: none"> - Ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх мэдлэг чадвар сайн. - Чөлөөт уран бүтээлчид, Мэргэжлийн холбоодтой хамтын түншлэл хэвийн түвшинд явагддаг. - Соёл, урлагийн 7 байгууллага эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон. 	<p>нь тогтмол зардал буюу цахилгаан, ус, дулааны зардалд зарцуулдаг.</p>
--	--

5.2 Гадаад орчны шинжилгээ: Гадаад орчны шинжилгээг хийхдээ улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүйн орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлсноор ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргав.

Соёл, урлагийн салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг олон улсын орчинд гарч буй өөрчлөлт нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан Монгол улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц байдлын тухай үндэсний илтгэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэс болгон энэхүү стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд хийсэн цогц судалгаа үр дүнг ашиглан PEST шинжилгээний аргаар төрийн бодлого, эдийн засаг, нийгэм, соёл, технологи гэсэн хүрээнд авч үзэж боловсруулав.

Гадаад орчин	
Боломж	Эрсдэл
1. Төрийн бодлого, эрх зүйн хүчин зүйлс (P)	
<ul style="list-style-type: none"> - Засгийн газар нутгийн удирдлагын байгууллагаас соёл, урлагийн салбар болон байгууллагыг хөгжүүлэх тодорхой зорилтууд дэвшүүлж, дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. - Соёл, урлагийн салбарт зах зээл хөгжсөн улс орнуудын нийтлэг жишиг туршлагаас өөртөө зохих ёсоор шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлэх шинэтгэлийн бодлого явагдаж байна. - Төрөөс соёлын салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж буйтай холбоотойгоор соёл, урлагийн байгууллагыг санхүүжүүлэх хувьсах зардлын норматив нэмэгдэж байна. Хөдөө орон нутагт ажиллаж буй соёлын ажилтнуудад ажилласан жилийн нэмэгдэл олгохоор шийдвэрлэсэн нь хүний нөөцийн тогтвортой байдалд нөлөөлнө. - Соёлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр “Үндэсний болон орон нутгийн онцлогтой соёл, үйлдвэрлэл үйлчилгээ, ард түмний эрэлт хэрэгцээг хангахад зайлшгүй шаардлагатай шилдэг уран бүтээл болон төсөл”-ийг төрөөс 	<ul style="list-style-type: none"> - Соёл урлагийн салбарт ажиллах менежер, судлаач, мэргэшсэн ажилтан болон уран бүтээлчдийг бэлтгэх ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх нэгдсэн тогтолцоо байхгүй төрийн дэмжлэг хязгаарлагдмал байна. - Соёл урлагийн салбарыг хөгжүүлэх хууль, эрх зүйн үндэс бүрэлдсэн боловч хуулиудийн хэрэгжилт хангалттай байгаа нь салбарын бие даах чадвар, санхүүгийн хувьд бүрэн баталгаажаагүйтэй холбоотой. - Улс төрчдийн шийдвэр, манлайлал, сонгуулийн тогтолцооноос хамааралтай шийдвэрлэх процесс удаан явагдаж байна. - Олон улсын байгууллагуудтай харилцах аймгийн соёл, урлагийн салбарын хамтын ажиллагаа, түншлэл хязгаарлагмал. - Гадаад, дотоодын ижил мэргэжлийн байгууллагатай харилцан туршлага солилцох, тоглолт хийх, мэргэжилтэн солилцох, курс дамжаанд сургах зардал төсөвт тусгагддаггүй. - Дархан-Уул аймаг нь Орос, БНХАУ БНСУ, Унгар улс, Канад улс зэрэг олон улс, хотуудтай найрамдал хамтын ажиллагаатай хэдий ч соёлын бодлого ба үйл ажиллагааг бүс нутгийн болон олон

<p>санхүүжүүлэх болсон. “Өөрөө өөрийгөө тэтгэх өрсөлдөх чадвартай соёлын үйлдвэрлэл үйлчилгээ”-г төрөөс эдийн засгийн талаар дэмжих болсон.</p> <ul style="list-style-type: none"> - Урлагийн бүх төрөл, зүйлийг анхааран хөгжүүлж, үндэсний уламжлалт, сонгодог болон “Хүүхдэд зориулсан уран бүтээл, баримтат киног төрийн ивээл”-д оруулсан, төрөөс дэмжлэг үзүүлдэг болсон. - Үндэсний агуулгатай орон нутгийн онцлогийг тусгасан брэнд соёлын үйлчилгээ үйлдвэрлэлийг бий болгох хөгжүүлэх үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх олон улсын түвшинд гаргах стратеги”-ийг тусгайлан хэрэгжүүлж, соёлийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн иргэдийн аливаа санаачлага, бүтээлч үйл ажиллагааг дэмжих эрх зүй, санхүүгийн дэмжлэг бүрдсэн нь өрсөлдөөний гол чиглэл болж байна. 	<p>улсын хэмжээнд идэвхжүүлж олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна.</p>
<p>2. Эдийн засгийн хүчин зүйлс (E)</p>	
<ul style="list-style-type: none"> - Соёлын үйлдвэрлэл нь дэлхийн улс орнуудын хувьд тэргүүлэх салбар, олон улсад өрсөлдөх давуу байдлыг олж авах боломжийг бүрдүүлж байна. - Соёлын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - 2500 хүний суудалтай Соёл, спортын цогцолбор 2023 онд ашиглалтад орно. - Музей-Номын сангийн цогцолборын барилга шинээр барьж байна. 2024 онд ашиглалтад орно. - Залуучууд театрт техник, тоног төхөөрөмжийн төсвийн дэмжлэг ихээхэн нэмэгдсэн. <p>3. Сумдын соёлын төвүүдийн барилгад их засвар хийгдсэн. Мөн лэд дэлгэц техник, тоног төхөөрөмжөөр хангасан.</p> <ul style="list-style-type: none"> - Соёл, урлагийн байгууллага олсон орлогоо тодорхой хэмжээнд захиран зарцуулах боломжийг 2019 онд эрх зүйн зохицуулалтаар ханган өгсөн. - 2018 оноос хойш соёлын ажилтны цалин 32-52%-иар нэмэгдсэн 	<ul style="list-style-type: none"> - Соёл урлагийн байгууллагын хөгжлийн бодлого төлөвлөлтийг хийж чадахгүй бол соёлын бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж чанар үр ашгийг дээшлүүлэх дотоод боломжийг алдсан хэвээр байх болно. - Улсын төсвөөс төрийн өмчийн соёл урлагийн байгууллагуудад тодорхой хэмжээний санхүүжилт өгч буй боловч санхүүгийн эрх мэдлийг бүрэн олгоогүй байгаа нь хөгжилтэй орнуудын түвшинд хүрэхүйц бүтээлч орчинг бүрдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжгүй байна. - Төсвийн мөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах эрх хязгаарлагдмал. - Төв номын сангийн архив, фонд зэрэг чухал объектуудад ойрын жилүүдэд засвар үйлчилгээ ороогүй. - Соёлын салбарын улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө тодорхойгүй.
<p>3. Нийгэм, соёлын хүчин зүйлс (S)</p>	
<p>-Дэлхий дахиныг хамарсан даяаршлын үйл явцын эрчимжилт технологийн хурдацтай хөгжил нь хүн ам соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг зөвхөн соёлын байгууллагаас</p>	<p>- Соёл урлагийн салбарт оюуны өмчийн талаарх ойлголт дутмаг, урлагийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах харилцаа хөгжөөгүй, хүн амд мөнгө төлөх</p>

<p>бус телевиз, интернетээс хүлээн авах боломжтой болсон</p> <ul style="list-style-type: none"> - Хүн амын соёл урлагийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүртэх эрэлт нэмэгдэхийн сацуу үзэгчдээс тавих шаардлага үнэлэмж нэмэгдэж байна. - Хүн амын урлагийн боловсролын эрэлт аж ахуйн нэгж байгууллагууд, ажилчдын чөлөөт цагт чиглэгдсэн зорилтот арга хэмжээнд ач холбогдол өгөх хандлага нэмэгдэж байна. - Шашны зөрчилдөөний асуудал байхгүй. 	<p>соёл төлөвшөөгүй, үнэгүйдүүлэх сэтгэлгээ давамгайлах байдалтай байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хотжилт түүнээс үүдсэн хүн амын төвлөрөл нь үндэсний урлаг соёлыг уусган өөрчлөх хандлагыг бий болгож байна. - Бүх нийтийн соёлын боловсролын түвшин доогуур байна. - Хүн амын шилжин ирэх урсгал эрс нэмэгдэж буйтай холбогдуулан соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн статустай болгон хүний нөөцөөр хангах, тэднийг бодлогоор чадваржуулахгүйгээр шинэ зууны шинэ үзэгчдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүйд хүрнэ. - Залуучууд театрт болон сумдын Соёлын төвүүдэд зохион байгуулах ажил хэт олон байгаа нь үндсэн үйл ажиллагааг явуулах боломжгүй болгодог.
4. Технологийн хүчин зүйлс (Т)	
<ul style="list-style-type: none"> - Шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх мэдээллийн технологийн боломж харьцангуй хангагдаж байгаа нь дэвшилтэт технологийн хайгуулыг тогтмол хийж, шинэ техник технологийг соёлын байгууллагууд үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжтой. - Өнөөгийн социал орчин нөхцөл тус салбарыг олон нийтэд таниулах боломжийг бий болгож байна. - Аймгийн соёл, урлагийн байгууллагууд инноваци технологи бүтээх талаар төсөл, хөтөлбөр боловсруулж хамгаалан төсвийн мөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах боломж хуулиар олгогдсон. -“Цахим соёл” арга хэмжээг хэрэгжүүлэх дижитал шилжилт хийх боломж нээгдсэн. 	<ul style="list-style-type: none"> - Соёл, урлагийн салбарын инновацийн идэвхжилт сул, инновацийн соёл төлөвшөөгүй, уламжлалт арга барилаар асуудалд хандах байдлаар илэрдэг. - Салбарын цахимжилт, мэдээллийн сан бүрдүүлэлт бүрэн хийгдээгүй. - Салбарын бүртгэл, мэдээлэл, статистикийн мэдээ бүрдүүлэлт ашиглалт хангалтгүй. - Соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын таатай нөхцөл орон нутгийн түвшинд сул байна.

5.3. Салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудал, далайц:

Салбар	№	Давтамж	Тулгамдаж буй асуудал
	1.1.	10/ 95	Аймгийн музей нь 1968 оны 5 дугаар сард орон нутаг судлах кабинет нэртэйгээр байгуулагдаж 1969 оны 10 дугаар сард Дархан хотын Үйлчилгээний төв баригдахад одоогийн музейн байранд шилжин байрласан. 1970 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр В.И.Лениний танхим, Д.Сүхбаатарын танхим нэртэй нэг танхим 500 үзмэртэй үйл ажиллагааг эхлүүлсэн.

Музей			Одоо 1000м2 бүхий талбайтай, үзмэрийн 4 танхимтай, 1300 сан хөмрөгтэй. 8 ажилтантай.
	1.2.	10/90	55 жил зориулалтын бус байранд байрласан. Үзмэр дэглэлт зохион байгуулахад стандарт шаардлага хангахгүй тул музейн стандартад нийцсэн зориулалтын байртай болох.
	1.3.	9/85	Музейн зориулалтын байр, орчин үеийн тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.
Залуучууд театр	2.1.	10/90	Театрын барилга 1978 онд ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжаар 800 суудалтай. Бэлтгэлийн болон уран бүтээлчдийн өрөөтэй. Барилга байгууламжийн стандартыг бүрэн хангасан хэдий ч “чанартай, хүртээмжтэй, сэтгэл ханамжийн өндөр баталгаатай уран бүтээл” туурвих шаардлага хангахуйц техник тоног төхөөрөмж дутагдалтай хэвээр байна.
	2.2.	10/95	Мэргэжлийн багш /концертмейстер, балетмейстр/ болон мэргэжлийн уран бүтээлчид дутагдалтай “мэргэжлийн болон хагас уран сайхны холимог шинж”-ийг агуулж байгаа нь мэргэжлийн урлагийн байгууллагын статус уран бүтээлийн чанарт сөргөөр нөлөөлж байна.
	2.3.	10/90	Хэрэглэгч үзэгчдийн хэрэгцээ, уран бүтээлийн туурвил, зах зээлийн маркетингийн судалгаанд тулгуурласан. Театрын урын сангийн бодлого, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамжид суурилсан, уран сайхны зөвлөлийн шийдвэрт үндэслэсэн “Уран бүтээл- төсөв санхүү - бодлого зохицуулалт”-ыг цогцоор нь авч үзэж шийдвэрлэх, уран сайхны зөвлөл уран бүтээлийн үйлдвэрлэлд хяналт тавьж ажилладаг, театрын өнөөгийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох “Удирдлагын шинэ менежмент”-ийг нэвтрүүлэх шаардлагатай.
	2.4.	9/85	Ажлын байрыг стандарт, жишигт нийцүүлэн тохижуулах, анги тус бүрт дасгал сургуулилалт хийх хөгжим техник хэрэгслээр хангах, тайз засалд анхаарах зэргээр үйлчлүүлэгчдэд таатай орчин бүрдүүлэх шаардлагатай.
	2.5.	9/95	Уран бүтээлчдийн орон тоо дутмаг, уран бүтээлийн зардал хүрэлцдэггүй, уран бүтээлчдийн хувцас хэрэглэл хуучирсан, хөгжимчдийн хөгжмийн зэвсэг шаардлагад бүрэн нийцэхгүй. /сургалтын хөгжимтэй/ гадаадад мэргэжлийн чиглэлээр сургах, туршлага

			судлуулах боломж хязгаарлагдмал, уран бүтээлчдийн нийгмийн асуудал бүрэн шийдэгдээгүй, уран бүтээлийн зах зээлийн судалгаа шинжилгээ хангалтгүй, ажиллагсад цалин нийгмийн хамгааллын чиглэлээр сэтгэл ханамж сул байна.
	2.6	9/95	Уран бүтээлчдийн тоо, театрт ажиллаж байгаа захиргаа аж ахуй, инженер техникчдийн ажилчдын тоотой адил тэнцүү /54/40/ шинжтэй байгаа нь урын сангийн бодлого, уран бүтээлийн үйл ажиллагаанд эерэг зохистой нөлөө үзүүлэхгүй.
Номын сан, Хүүхдийн номын ордон	3.1.	8/95	Орчин үеийн номын сангийн үйлчилгээний стандарт хангасан зориулалтын номын сангийн байртай болох, одоогийн номын сангийн барилга нь Залуучууд театрын барилгын нэгэн хэсэг. Стандартын шаардлага хангахгүй тавилга тоног төхөөрөмж, үйлчилгээний орчин нөхцөл стандарт бус үйлчилгээний танхимуудтай.
	3.2.	8/95	Архивын фонд /түүх соёлын ховор номын хадгалалт хамгаалалт/ зориулалтын биш, цахилгаан, дулаан, агааржуулалтын өрөө тасалгааны зохион байгуулалт стандарт бус, ном сэтгүүл сэргээн засварлах, нэмж сан бүрдүүлэх төсөв санхүү байхгүй.
	3.3.	10/95	Номын сангийн мэргэжлийн хүний нөөц дутмаг, өнөөгийн нөхцөлд номын сангийн бүтэц, зохион байгуулалт оновчтой бус.
	3.4.	10/90	Мэдээллийн технологид суурилсан уламжлалаа хадгалсан брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох замаар хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай.
	3.5.	8/95	Алслагдсан гэр хороолол сумдад зориулалтын номын сангийн байртай болох нэн шаардлага тулгараад байна.
	3.6.	9/85	Номын сангийн цахим нөөц хангалтгүй, фонд бүрдүүлэлт фондын бүтэц чанар алдагдсан. Цаасан каталогиос татгалзаж цахим сан бүрдүүлэхэд төсөв санхүү, хүн хүч, техник хэрэгсэл дутмаг.
	3.7.	8/85	Нийгэм олон нийт рүү хандсан соён гэгээрүүлэх ажлын төсөв мөнгө, гадаад харилцаа хамтын ажиллагаа хангалтгүй.
	3.8.	9/95	Алслагдсан сум суурины уншигч, үйлчлүүлэгч болон нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай зорилтот бүлэгт чиглэсэн “Номын нүүдэл, зөөврийн үйлчилгээ”-ний зардлын төсөв бага, хүрэлцээгүй.
	3.9.	9/85	Мэргэжлийн боловсрон хүчний мэргэжил дээшлүүлэх сургалтын нэгдсэн тогтолцоо хангалтгүй. Уран бүтээл хийх, ном, үзмэр худалдан авах зардал бага.

Соёлын төв	4.1.	10/95	Сумдын соёлын төвүүдийн барилгыг шинээр барих, өргөтгөх замаар нөхцөлийг сайжруулж ажлыг шат дараатай хэрэгжүүлж стандарт хангасан Соёлын төвийг бий болгох шаардлагатай.
	4.2.	9/90	Сумдын соёлын төвүүдэд соёл, урлагийн мэргэжлийн боловсон хүчин дутмаг.
	4.3.	9/90	Сумдын соёлын төвүүдийг суурин болон зөөврийн техник тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай.
Кино урлаг	5.1.	9/90	Аймгийн төвд орчин үеийн кино урлагийн технологийн шийдэл бүхий нэг кино театртай. Сумдад кино үзвэрийн орчин нөхцөл бий болгох шаардлагатай.
	5.2.	10/95	Хөдөө сум, алслагдсан баг суурингийн иргэдэд явуулын кино үйлчилгээ үзүүлэх, кино урлагийн үндэсний нэгдсэн сүлжээнд хамрагдах, Мэргэжлийн кино театруудтай сүлжээ үүсгэх.
Чөлөөт уран бүтээлчид	6.1.	10/95	Аймгийн хэмжээнд хувийн болон чөлөөт уран бүтээлчдийн нэгдэл байгуулагдаагүй. Төрийн дэмжлэг бага.
Хэвлэл мэдээллийн байгууллага	7.1.	9/85	Цалингийн сүлжээний хувь хэмжээ доогуур, төрөл бүрийн нийгмийн халамж үйлчилгээнд хамрагддаггүй /орон нутгийн 5 жил дутамд олгодог урамшуулал, орон сууцны хөнгөлөлттэй зээл тусламж г.м/

5.4 Өнөөгийн байдалд хийсэн нэгдсэн дүгнэлт, стратегийн томъёоллууд:

Код	Нэгдсэн дүгнэлт	Стратегийн томъёоллууд:
SM	SM1: Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын ажлын төлөвлөлт “байгууллагын менежментийн бодлого “стратегийн удирдлагын түвшин”-д төлөвлөгдөөгүй, салбарын урт хугацааны хөгжлийн замын зураглалгүй байгаа нь “соёл урлагийн салбарын тогтвортой хөгжлийн зорилт” хүссэн үр дүн”-д хүрч чадахгүй байна. Төрөөс соёлын шинэчлэлийн талаар явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь байгууллага бүрийг өөрийн онцлог давуу тал дээрээ суурилан хөгжих нөхцлийг бүрдүүлж байна. Энэ нь соёлын салбарт хөгжлийн хэтийн төлөвлөгөө боловсруулах зайлшгүй шаардлагатай.	SM1-1: Салбарын бодлогын залгамж холбоог хадгалан өөрийн онцлогт тохирсон <i>Стратеги - менежментийн удирдлага</i> ”-ыг аймгийн соёл, урлагийн салбарын бүх түвшинд нэвтрүүлж “ <i>Үр дүнд суурилсан удирдлага - гүйцэтгэлд тулгуурласан менежмент</i> ” бүхий соёл урлагийн дунд хугацааны стратегийн төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.
	SM2: Хүн амын шилжин сууршилт, хотжилт, бүс нутгийн эдийн засгийн	SM2-1: Улс төр эдийн засаг нийгэм хүн ам зүйн хүчин зүйл, хурдацтай, нээлттэй,

CaR	<p>хөгжил үйлдвэржүүлэлттэй уялдуулан хүн амын өсөн нэмэгдэж байгаа соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, <i>үйлчилгээ хүртээгчдийн шинэ эрэлт хэрэгцээнд нийцсэн соёл үйлчилгээний барилга байгууламж</i> барих, өргөтгөх шинэчлэх шаардлага тулгарсан байна.</p>	<p>өрсөлдөөнтэй мэдээлжсэн нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн <i>аймгийн соёл урлагийн салбарт эрчимтэй өргөжилт тэлэлт</i> хийх замаар хүн амын өсөн нэмэгдэж байгаа соёл, урлагийн эрэлт хэрэгцээг хангана.</p>
CuA	<p>SM3: Дэлхийн болон үндэсний, соёл урлагийн үзвэр үйлчилгээний тоо нэр төрөл чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдээлэх, соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, орчин нөхцөл бүрдүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэхэд чиглэсэн, орон нутгийн онцлогийг хадгалсан <i>“Соёл урлагийн шинэ үйлчилгээ-үйлдвэрлэл”</i>-ийг бий болгох хэрэгцээ өссөн байна.</p>	<p>SM3-1: Дэлхийн болон үндэсний соёл урлагийн ололт бүтээлээр дамжуулан иргэдэд “Хотын соёл иргэний стандартыг төлөвшүүлж шинэ зууны ухаалаг, соёлтой үзэгчид”-ийг соёл, урлагийн бүх салбарт бэлтгэнэ.</p> <p>SM3-2: Аялал жуулчлал - соёлын үйлдвэрлэл”-ийн хосолмол загвар-ыг хөгжүүлнэ. Соёлын аялал жуулчлал, аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн, тусгай сонирхлын аялал жуулчлал зэрэг шинэ үйлчилгээг нэвтрүүлж эдийн засгийн эргэлтэд оруулна.</p>
CuHR	<p>SM4: Мэргэжлийн түвшинд сайтар бэлтгэгдсэн авьяас билэгтэй, өндөр ур чадвартай, урам зориг бүхий чадварлаг ураг бүтээлчид, соёлын ажилтаны <i>“үр ашигтай тогтолцоо, зохистой удирдага, сайн хангагдсан нөөц бүхий орчинд тогтвортой ажиллах боломж”</i>-ийг бүрдүүлнэ.</p>	<p>SM4-1: Соёл урлагийн салбарын уран бүтээлчид, ажилтнуудын харилцаа, хандлага, мэдлэг мэргэжил арга зүй технологийг шинэ зуунд тавигдаж буй шаардлагад нийцүүлэн хувь хүний суурь хөгжлийг хангасан <i>“Суралцагч байгууллага”</i>, <i>“Өндөр бүтээмжид хамт олон”</i>, <i>“Инновацид тулгуурласан байгууллага”</i> болох стратегийг салбарын түвшинд жигд хэрэгжүүлнэ.</p>
		<p>SM4-1: Үйлчилгээний нэр төрөл чанар үр дүн материаллаг орчин үйл ажиллагааны менежмент зэрэг бүхий л талаараа хөгжсөн <i>хувийн хэвшлийн соёлын байгууллага ААН ТББ иргэний санаачлага</i> үйлчилгээг бий болгоход удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлж төрийн болон хувийн хэвшлийн соёлын байгууллагад тэгш хандах зарчим баримтална.</p>

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО;

6.1 ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, СТРАТЕГИУД:

Стратегийн зорилго, үндсэн чиглэлүүдийг стратеги төлөвлөлтийн АНР аргыг SWOT шинжилгээний аргатай хослуулан хэрэглэж салбарын үйл ажиллагааны эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд 2022-2024 онд баримтлах үйл ажиллагааны стратегийн зорилгыг дараах байдлаар тодорхойллоо.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж музейн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдийн өвийг сурталчлах, төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. Урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. Утга зохиол, ном хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5. Бүх нийтийн соёлын боловсролыг дэмжиж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 6. Дүрслэх урлаг, зураг, дизайн, гар урлал болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 7. Аудио, видео, интерактив медиа, кино үзвэр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 8. Мэргэжлийн ур чадвартай ажилтнуудыг бэлтгэх, сургахад анхаарч гадаад, дотоодын соёлын байгууллагуудтай хамтран ажиллана.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

7.1 СТРАТЕГИ ЗОРИЛТУУД:

Аймгийн соёл, урлагийн салбарын үйл ажиллагааны стратегийн зорилго тус бүрийг хэрэгжүүлэх зорилгоор дор дурдсан үйл ажиллагааны стратегийг тодорхойллоо.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж музейн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 1.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалт, гадна өнгө төрх, сэргээн засварлалтын ажлыг сайжруулна.

Зорилт 1.2 Түүх, археологийн хайгуул судалгаа малтлагын ажлыг үе шаттай зохион байгуулна.

Зорилт 1.3 Түүх, Соёлын хөдлөх дурсгалын үзмэр баяжилтыг нэмэгдүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

Зорилт 1.4 Орон нутаг судлах танхимын үйлчилгээний чанар хүртээмж, үзүүлэлт дэглэлт, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

Зорилт 1.5 Музей, Номын сангийн цогцолбор барилгын үзүүлэлт, дэглэлтийг стандартын дагуу хэрэгжүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, сурталчлах, төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

Зорилт 2.1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг бүх шатанд эрчимжүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. Урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 3.1 Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Зорилт 3.2 Сумдын соёлын төвийн үзвэр, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

Зорилт 3.3 Уламжлалт баяр наадам, задгай талбайн тоглолт, арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. Утга зохиол, ном хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Зорилт 4.1 Утга зохиол, ном хэвлэлийн зохион туурвигчдын бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжинэ.

Зорилт 4.2 Бүх шатны номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5. Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

Зорилт 5.1 Иргэдийг угийн бичиг хөтлөх арга зүйгээр хангах, ач холбогдлын талаар хүүхэд залуучуудад бага наснаас нь ойлголт хандлага бий болгоно.

Зорилт 5.2 Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэнэ.

Зорилт 5.3 Соёл, гэгээрлийн олон талт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 6. Дүрслэх урлаг, зураг, дизайн, гар урлал болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

Зорилт 6.1 Дүрслэх урлагийн бүтээл гаргах, олон нийтэд толилуулах, зохиогчийн эрхийн зөвшөөрөл авах ажил дээр хамтарч ажиллах.

Зорилт 6.2 Үндэсний уламжлалт гар урлалын үйлдвэрлэл үйлчилгээг дэмжинэ.

Зорилт 6.3 Уран зураг, уран баримал, зураач урчуудын бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 7. Аудио, видео, интерактив медиа, кино үзвэр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 7.1 Орон нутгийн телевиз, радиогийн уран сайхны нийтлэл нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.

Зорилт 7.2 Дархан-Уул аймгийн хэмжээнд кино театрын үзвэр, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 8. Мэргэжлийн ур чадвартай ажилтнуудыг бэлтгэх, сургахад анхаарч гадаад, дотоодын соёлын байгууллагуудтай хамтран ажиллана.

Зорилт 8.1 Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 8.2 Соёлын салбарын хамтын ажиллагаа, түншлэлийн олон талт хэлбэрүүдийг бий болгоно.

7.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ БУЮУ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги арга зам	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. СОЁЛЫН ӨВИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ МУЗЕЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.					
Зорилт 1.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалт, гадна өнгө төрх, сэргээн засварлалтын ажлыг сайжруулна.	Арга хэмжээ 1.1.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн харуул хамгаалалтыг гэрээт аж ахуй нэгж, хувь хүнд хариуцуулна.	Аж ахуй нэгж, хувь хүнд хариуцуулсан тоо	-	Жилд 2-оос доошгүй дурсгалт зүйлсийг хариуцуулсан байна.	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 1.1.2 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг сэргээн засварлана.	Сэргээн засварласан дурсгалын тоо	-	Жилд 4-өөс доошгүй дурсгалыг засварласан байна.	Орон нутгийн төсөв
Зорилт 1.2 Түүх, археологийн хайгуул судалгаа малтлагын ажлыг үе шаттай зохион байгуулна.	Арга хэмжээ 1.2.1 Сяньбигийн үеийн хаад язгууртны бухант булшны малтлага судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийхэд улс, орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.	- Судалгааны тоо - Олдворын тоо	2022 оны байдлаар 20 гаруй олдвор олдсон.	Олдворыг сэргээн засварлаж түүх, он цаг хугацааг тодорхойлох зэргээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийгдсэн байна.	Орон нутгийн төсөв 70,0 сая
	Арга хэмжээ 1.2.2 Түүх, археологийн хайгуул судалгаа малтлагын ажлын үр дүнг иргэдэд	- Олдворын тоо - Үйл ажиллагааны тоо	Олдворыг судалгааны баг УБ хот руу авч явсан.	Олдворыг төв, орон нутгийн музейд хадгалуулах, сурталчлах зэрэг	Үйл ажиллагаагаар

	олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.			ажлууд хийгдсэн байна.	
Зорилт 1.3. Түүх, соёлын хөдлөх дурсгалын үзмэр баяжилтыг нэмэгдүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Арга хэмжээ 1.3.1 Музейн үзмэр баяжилт нэмэгдүүлнэ.	Баяжилт хийгдсэн үзмэрийн тоо	2022 онд 37 нэмэгдсэн.	Жилд 20 доошгүй үзмэр баяжилт хийгдсэн байна.	Улсын болон орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 1.3.2 Урлаг, уран сайхны холбогдолтой дурсгалын баяжилтыг нэмэгдүүлнэ.	Дурсгалын тоо	-	Жилд 2 үзмэр баяжилт хийгдсэн байна.	Улсын болон орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 1.3.3 Уран зургийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, сэргээн засварлах төсөл арга хэмжээг дэмжиж хэрэгжүүлнэ.	Сэргээн засварласан зургийн тоо	-	Төсөл хэрэгжүүлсэн байна.	Улсын болон орон нутгийн төсөв
Зорилт 1.4 Орон нутаг судлах танхимын үйлчилгээний чанар хүртээмж, үзүүлэл дэглэлт, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Арга хэмжээ 1.4.1 Орон нутаг судлах танхимуудад үзмэр баяжилтыг нэмэгдүүлэх дэглэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	Баяжилт хийгдсэн үзмэрийн тоо Хамтарч ажилласан ОНСТ-ын тоо	2 сумдад зөвлөн туслах үзүүлсэн.	ОНСТ-ын үзмэр баяжилт нэмэгдэж үйл ажиллагаа сайжирсан байна.	Улсын болон орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр, ААН-ийн хандив
	Арга хэмжээ 1.4.2 Орон нутгийн иргэдэд соёлын өвийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн эзлэх хувь	-	Иргэдэд соёлын өвийг сурталчлан таниулсан байна.	Улсын болон орон нутгийн төсөв
Зорилт 1.5 Музей, Номын сангийн цогцолбор барилгын үзүүлэл, дэглэлтийг	Арга хэмжээ 1.5.1 Музей, Номын сангийн цогцолборын барилгын үзүүлэл дэглэлт, үзэл баримтлалыг	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	Мэргэжлийн судалгааны туршлагатай баг бүрдүүлж, Музей-Номын	Улсын болон орон нутгийн төсөв

стандартын хэрэгжүүлнэ.	дагуу боловсруулах ажлын хэсгийг байгуулж, боловсруулж батлуулна.			сангийн үзэл баримтлалаа тодорхойлсон байна.	
	Арга хэмжээ 1.5.2 Музей-Номын сангийн үзэл баримтлалын дагуу мэргэжлийн байгууллагууд нүүлгэлт, үзүүлэг дэглэлт зэрэг төлөвлөгөө боловсруулж батлуулна.	Төлөвлөгөө	-	Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаануудыг зохион байгуулсан байна.	Улсын болон орон нутгийн төсөв
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫГ НЭЭН ИЛРҮҮЛЭХ, СУРТАЛЧЛАХ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ ДЭМЖИЖ АЖИЛЛАНА.					
Зорилт 2.1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг бүх шатанд эрчимжүүлнэ.	Арга хэмжээ 2.1.1 Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдийг нээн илрүүлж www.ich.mongoluv.mn бүртгэл мэдээллийн санд бүртгэнэ.	Өвлөн уламжлагчдын тоо	90 өвлөн уламжлагч	Цахим мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ 2.1.2 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын үзлэг тооллогыг зохион байгуулна.	4 жилд нэг удаа зохион байгуулна.	2021 онд хийсэн	Үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ 2.1.3 Мартагдах, устах аюулд ороод буй Соёлын биет бус өвийг сэргээх, өвлөн уламжлуулах Шавь сургалтуудыг дэмжинэ.	2022 оны үзлэг судалгаагаар эх хэл аман уламжлалын ай савын төрлүүд тодорхойлогдсон.	-	Өвлөн уламжлагчдыг дэмжин ажилласан байна.	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ 2.1.4	3 жилд нэг удаа өвлөн	-	Соёлын биет бус өвийг өвлөн	Орон нутгийн төсөв

	Соёлын биет бус өвийн улс, бус, аймгийн чанартай наадмуудад идэвхтэй оролцоно.	уламжлагчдын наадамд оролцонон.		уламжлагчдыг алдаршуулах	70.0 сая
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. УРЛАГИЙН ТОГЛОЛТ, ҮЗВЭР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.					
Зорилт 3.1 Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	Арга хэмжээ 3.1.1 Мэргэжлийн урлагийн байгууллагын урын санг шилдэг бүтээлээр баяжуулна.	Бүтээлийн тоо	2 шинэ уран бүтээл туурвисан байна	Жилд 2 шинэ уран бүтээл туурвисан байна.	Орон нутгийн төсөв болон төсөл хөтөлбөрөөр
	Арга хэмжээ 3.1.2 Соёл, урлагийн чиглэлээр “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	Хэрэгжилтийг 60 хувьд хүргэнэ.	Улсын болон Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.1.3 Санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмийг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай шуурхай хүргэнэ.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	Үр дүнтэй хэрэгжүүлсэн байна	Улсын болон Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.1.4 Соёлын суурь судалгааг хийж хамрах цар хүрээ, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, үзэгчдийн үзвэр үйлчилгээний чиг хандлага, сэтгэл ханамжийн судалгаа, үйлчилгээний ангилал	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	2022 оны байдлаар 1 судалгаа хийгдсэн. 110 хүн хамрагдсан	Судалгааг хэрэгжүүлсэн байна	Үйл ажиллагааны зардал

	жагсаалтыг гаргаж хэрэгжүүлнэ.				
	Арга хэмжээ 3.1.5 Тоног төхөөрөмж, хувцасны шинэчлэл хийнэ.	Тоног төхөөрөмжийн тоо	2021 оны суурь түвшин гэрэлтүүлэг тоног төхөөрөмжид 114 600 000 төгрөг	Мэргэжлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна	Улсын болон Орон нутгийн төсөв
Зорилт 3.2 Сумдын соёлын төвийн үзвэр, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	Арга хэмжээ 3.2.1 Жишиг соёлын төвүүдийг бий болгоно.	Соёлын төвийн тоо	-	Жишиг соёлын төвтэй болсон байна.	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.2.2 Соёлын төвүүд соёлын олон талт үйлчилгээг бүх насны иргэдэд хүртээмжтэй, чанартай, шуурхай хүргэнэ.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	Үзэгчдийн эрэлт, сэтгэл ханамж дээшилсэн байна.	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.2.3 Үзвэр үйлчилгээний гадаад дотоод орчныг шинэчлэн сайжруулна.	Шинэчлэн сайжруулсан арга хэмжээний тоо	-	Шинэчлэлт хийсэн байна.	Улсын болон Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.2.4 Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.	Тоног төхөөрөмжийн тоо	-	Шинэчлэл хийсэн байна.	Улсын болон Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.2.5 Хүүхэд багачуудад зориулсан соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.	Бүтээлийн тоо	-	Соёлын инноваци, орон нутгийн брэндийг бий болгосон байна.	Улсын болон Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.2.6 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин	Зохион байгуулсан ажлын тоо	-	Соёл мэдээллийн	Улсын болон Орон нутгийн төсөв

	хамтарч ажиллах, Өрсөлдөх чадвар бүхий орон нутгийн брэндийг бий болгоход санаачлагатай бүтээлч оролцоно.			төвтэй болсон байна.	
	Арга хэмжээ 3.2.7 Соёлын төвийн үйл ажиллагаанд тавих шаардлага, стандартыг мөрдөж ажиллана.	Стандартын шаардлага хангасан соёлын төвийн тоо	-	Стандартын шаардлага ханган ажилласан байна	Улсын болон Орон нутгийн төсөв
Зорилт 3.3 Уламжлалт баяр наадам, задгай талбайн тоглолт, арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна.	Арга хэмжээ 3.3.1 Соёлын орон зайг бий болгосон үйл ажиллагаануудыг зохион байгуулна.	Иргэдэд үзүүлсэн үйлчилгээний тоо	-	Соёлын орон зайг бий болгох төлөвлөгөөг гаргасан байна.	Улсын болон Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.3.2 Үндэсний их баяр наадмын урлаг, соёлын үйл ажиллагааг зохион байгуулна.	Уран бүтээлийн тоо	-	Үйл ажиллагааг чанартай зохион байгуулсан байна.	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 3.3.3 Дархан хотын ойн баярын хүрээнд урлаг, соёлын үйл ажиллагааг зохион байгуулна.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	Үйл ажиллагааг чанартай зохион байгуулсан байна.	Орон нутгийн төсөв
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА.					
Зорилт 4.1 Утга зохиол, ном хэвлэлийн зохион туурвигчдын бүтээн	Арга хэмжээ 4.1.1 Үндэсний номын баяр, Уншлага үйлчилгээ, Зохиолч-уншигчдын уулзалт, шинэ шилдэг номын сурталчилгаа зэрэг	Хамрагдсан иргэдийн тоо, Зохион байгуулсан ажлын тоо	Өдөрлөг - 13 удаа, 3423 хүн	Ирэгсдийн тоо өссөн байна	Улсын болон Орон нутгийн төсөв

туурвих үйл ажиллагааг дэмжинэ.	соёл олон нийтийн арга хэмжээг зохион байгуулна.				
	Арга хэмжээ 4.1.2 Эх хэл, түүх соёлоо эрхэмлэн дээдэлсэн, эрүүл чийрэг, эх оронч, бүтээлч Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо, Оролцсон хүүхэд багачуудын тоо	5 арга хэмжэээ 1523 хүн	Хамрагдсан хүний тоо өссөн байна	Орон нутгийн төсөв
Зорилт 4.2 Бүх шатны номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.	Арга хэмжээ 4.2.1 Технологийн дэвшилд суурилсан цахим сан хөмрөг бий болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлнэ.	Цахим үйлчилгээний тоогоор, Цахим сан хөмрөгийн эзлэх хувь	Архивын фондын -250 боть ном, нийт 2872 боть номыг нэг бүрчилсэн бүртгэлд бүртгэлээ.	Сан хөмрөгийг цахимд шилжүүлсэн байна	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ 4.2.2 Номын сангууд уншигчдын эрэлт хэрэгцээ, захиалгад үндэслэн жил бүр сан хөмрөгөө баяжуулна.	-Жил бүрийн фонд баяжилтад зарцуулсан хөрөнгө -Шинээр худалдан авсан номын тоо	72945 сан хөмрөг	Сан хөмрөгийн баяжилт өснө.	Улсын болон Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 4.2.3 Аймгийн нийтийн номын сангаас төрийн байгууллага, алслагдсан сургууль, цэцэрлэг, баг, төвүүдэд зөөврийн болон нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүлнэ.	-Үйлчилгээ үзүүлсэн төрийн байгууллага, алслагдсан сургууль, цэцэрлэг, багийн тоо -Хамрагдсан иргэдийн тоо	2022 онд 39 удаа давхардсан тоогоор 5224 иргэнд 12,101 ном олгосон.	Уншигчдын тоо нэмэгдэнэ.	Үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ 4.2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй	-Арга зүйн зөвлөгөө өгсөн номын сангийн тоо	28 байгууллага 33 номын санчдад	Номын сангуудын үйл	Үйл ажиллагааны зардал

	номын сангуудыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллана.			ажиллагаа сайжирна.	
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5: БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ БҮХ ТАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИНЭ.					
Зорилт 5.1 Иргэдийг угийн бичиг хөтлөх арга зүйгээр хангах, ач холбогдолын талаар хүүхэд залуучуудад бага наснаас нь ойлголт хандлага бий болгоно.	Арга хэмжээ 5.1.1 Угийн бичиг хөтлөх арга зүйгээр хангах, лекц сургалт зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил, Оролцсон иргэдийн тоо	Лекц- 10 удаа, 769 хүн	Хамрагдсан хүний тоо өссөн байна	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 5.1.2 Дархан-Уул аймагт Угийн бичиг хөтөлдөг иргэдийг илрүүлж орон даяр алдаршуулна.	Оролцсон иргэдийн тоо	-	Хамрагдсан хүний тоо өссөн байна	Орон нутгийн төсөв
Зорилт 5.2 Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэнэ.	Арга хэмжээ 5.2.1 Төрийн албан хаагчид, иргэдийн дунд монгол бичгийн сургалтыг тогтмол зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил, Оролцсон иргэдийн тоо	-	Хамрагдсан хүний тоо өссөн байна	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 5.2.2 Аж ахуйн нэгж төрийн болон төрийн бус байгууллагын дунд “Хос бичигтэн” болох аяныг өрнүүлнэ.	Зохион байгуулсан ажил, Оролцсон иргэдийн тоо	-	Хамрагдсан хүний тоо өссөн байна	Үйл ажиллагаа
Зорилт 5.3 Соёл, гэгээрлийн олон талт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.	Арга хэмжээ 5.3.1 Үндэсний хэл соёл, ёс заншлаа сурталчлах, түгээн дэлгэрүүлэх уралдаан тэмцээн, өдөрлөг арга хэмжээнүүдийг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт	Зохион байгуулсан ажил, Оролцсон иргэдийн тоо	-	Хамрагдсан хүний тоо өссөн байна	Орон нутгийн төсөв

	тохируулан зохион байгуулна.				
	Арга хэмжээ 5.3.2 Хотын соёлыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил, Оролцсон иргэдийн тоо	-	Хамрагдсан хүний тоо өссөн байна	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 5.3.3 Соёлын бүтээлч сарын хүрээнд идэвх санаачлагатай ажилласан байна.	-Үйл ажиллагааны тоо -Үзэгчдийн тоо	134 үйл ажиллагаа, 69050 үзэгчид	Иргэд, олон нийтэд соёл, урлагийн боловсролын түвшинг дээшлүүлнэ.	ОНТ, төсөл хөтөлбөрийн зардал
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 6. ДҮРСЛЭХ УРЛАГ, ЗУРАГ, ДИЗАЙН, ГАР УРЛАЛ БОЛОН СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИЖ АЖИЛЛАНА.					
Зорилт 6.1 Дүрслэх урлагийн бүтээл гаргах, олон нийтэд толилуулах, зохиогчийн эрхийн зөвшөөрөл авах ажил дээр хамтарч ажиллах.	Арга хэмжээ 6.1.1 Улс, бүс, орон нутгийн чанартай уран зургин үзэсгэлэнд орон нутгийн зураачдыг оролцуулна. Үзэсгэлэн гаргахад болон зохиогчийн эрхийн зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлнэ.	- Уран бүтээлийн тоо -Үзэсгэлэнгийн тоо	Жил бүр 1 уран бүтээлч буюу уран бүтээлийн 1-ээс доошгүй үзэсгэлэн	Уран бүтээлчдийг дэмжиж ажиллах, бүтээлээ худалдах зэрэг давуу талтай.	Орон нутгийн төсөв, тухайн уран бүтээлчийн үйл ажиллагааны зардал
	Арга хэмжээ 6.1.2 Уран зураг, уран баримал, зураач урчуудын бүтээн туурвих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	- Дэмжлэг үзүүлсэн уран бүтээлчийн тоо - Зарцуулсан хөрөнгө	-	Дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана	ОНТ
Зорилт 6.2 Үндэсний уламжлалт гар урлалын үйлдвэрлэл үйлчилгээг дэмжинэ.	Арга хэмжээ 6.2.1 Олон улсын чанартай фестиваль, наадам, үзэсгэлэнд оролцуулж, тэдгээрт дэмжлэг үзүүлнэ.	- Үзэсгэлэнд оролцсон хүний тоо - Дэмжлэг үзүүлсэн хүний тоо	-	Дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана	ОНТ, ААН-ийн хандив, дэмжлэг

<p>Зорилт 6.3 Уран зураг, уран баримал, зураач урчуудын бүтээн туурвих үйл ажиллагааг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Арга хэмжээ 6.3.1 Дүрслэх урлаг, уран барилга, дизайны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг уран бүтээлч нартай хамтарч ажиллана.</p>	<p>- Дэмжлэг үзүүлсэн уран бүтээлчийн тоо - Хамтарч ажилласан ажлын тоо - Зарцуулсан хөрөнгө</p>		<p>Дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана</p>	<p>ОНТ, ААН-ийн хандив, дэмжлэг</p>
<p>СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 7: АУДИО, ВИДЕО, ИНТЕРАКТИВ МЕДИА, КИНО ҮЗВЭР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.</p>					
<p>Зорилт 7.1 Орон нутгийн телевиз радиогийн уран сайхны нийтлэл нэвтрүүлгийн бодлого үйл ажиллагааг дэмжинэ.</p>	<p>Арга хэмжээ 7.1.1 Орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана.</p>	<p>Хамтарч ажилласан тоо</p>	<p>-</p>	<p>Иргэд, олон нийтэд соёл, урлагийн мэдээ мэдээллийг сурталчлан ажилласан байа</p>	<p>ОНТ, төсөл хөтөлбөрийн зардал</p>
	<p>Арга хэмжээ 7.1.2 Орон нутгийн түүхийн дурсгал, дурсгалт газруудыг түшиглэн Монгол ардын урлаг, өв соёлыг сурталчлан таниулсан дэлгэцийн бүтээл, контент бэлтгэн үзэгчдийн хүртээл болгоно.</p>	<p>- Сурталчилан таниулсан дурсгалт газрын тоо - Зохион байгуулсан ажил, контентын тоо</p>	<p>-</p>	<p>Дархан-Уул аймгийн түүхийн дурсгалт газрууд болон ардын урлаг, өв соёлыг иргэд, хүүхэд залуучуудад сурталчилан таниулсан байна.</p>	<p>ОНТ, төсөл хөтөлбөрийн зардал</p>
<p>Зорилт 7.2 Дархан-Уул аймгийн хэмжээнд кино театрын үзвэр, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.</p>	<p>Арга хэмжээ 7.2.1 Кино театрын үзвэр үйлчилгээг сурталчилан таниулах, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.</p>	<p>-Үйл ажиллагааны тоо</p>	<p>-</p>	<p>Үзвэр, үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байна.</p>	<p>Үйл ажиллагааны зардал</p>
	<p>Арга хэмжээ 7.2.2 Сумдын соёлын төвийн кино үзвэр үйлчилгээний</p>	<p>- Үйлчлүүлсэн иргэдийн тоо - Гаргасан киноны тоо</p>	<p>-</p>	<p>Иргэдийн сэтгэл ханамж сайжирна.</p>	<p>Үйл ажиллагааны зардал</p>

	чанар хүртээмжийг дээшлүүлнэ.				
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 8. МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРТАЙ АЖИЛТНУУДЫГ БЭЛТГЭХ, СУРГАХАД АНХААРЧ ГАДААД, ДОТООДЫН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА.					
Зорилт 8.1 Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлнэ.	Арга хэмжээ 8.1.1 Соёл, урлагийн салбарт нэн шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин хүний нөөцийг бэлтгэнэ.	Бэлтгэгдсэн хүний нөөцийн тоо	Мэргэжилтэй ажилтны тоо 106	Хүний нөөцийн мэдлэг, ур чадвар сайжирсан байна	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 8.1.2 Албан хаагчдыг төлөвлөгөөт болон чадавхжуулах сургалтад үе шаттайгаар хамруулна.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2022 оны 12 дугаар сарын байдлаар 146 хүн хамрагдсан нь 90%-тай байна	Төлөвлөгөөт болон чадавхжуулах сургалтад үе шаттайгаар хамруулсан байна.	Орон нутгийн төсөв, Байгууллагын төсөв
Зорилт 8.2 Соёлын салбарын хамтын ажиллагаа, түншлэлийн олон талт хэлбэрүүдийг бий болгоно.	Арга хэмжээ 8.3.1 Аж ахуйн нэгж байгууллагуудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэн төлөвшүүлэх замаар соёл урлагийн арга хэмжээнд татан оролцуулж санхүү болон бусад дэмжлэг тусалцаа үзүүлэх санаачилга хөдөлгөөн өрнүүлнэ.	Зохион байгуулсан ажлын тоо	-	Соёлын салбар дахь түншлэлийн олон талт хэлбэрүүдийг бий болгосон байна.	Орон нутгийн төсөв, ААНБ, иргэдийн төсөв
	Арга хэмжээ 8.3.1 Дотоод, гадаадын ижил түвшний соёлын байгууллагуудтай хамтран ажиллана.	Хамтран ажилласан байгууллагын тоо Үйл ажиллагааны тоо	-	Хамтын ажиллагаа сайжирсан байна.	Орон нутгийн төсөв, ААНБ, төсөв

НАЙМ. СТРАТЕГИ ЗОРИЛГО БА БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА

8.1 САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

8.1.1 Салбарын үйл ажиллагааны ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав.

➤ **Стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим**

(үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

➤ **Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим**

(бүтцийн нэгжүүд, тэдгээрийн нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ эрхлэх ажлын болон бусад байгууллагын зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

➤ **Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим**

(Салбарын нэр, бүтцээс тухайн салбарын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, салбарын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

➤ **Бүтэц энгийн байх зарчим;**

➤ **Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим;**

Салбарын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар, шуурхай удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгч, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);

➤ **Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим**

(үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).


8.1.2 СТРАТЕГИЙН ЗОРИЛТ БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ХАРИЛЦАН УЯЛДАА:

Стратегийн зорилго нь өөр хоорондоо нягт уялдаатай бөгөөд зорилгыг хэрэгжүүлэхдээ салбарын байгууллагууд нь үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.

Стратегийн зорилго нь өөр хоорондоо нягт уялдаатай бөгөөд зорилгыг хэрэгжүүлэхдээ салбарын байгууллагууд нь үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.

Стратегийн зорилго нь өөр хоорондоо нягт уялдаатай бөгөөд зорилгыг хэрэгжүүлэхдээ салбарын байгуулагууд нь үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



8.1.3 Стратеги төлөвлөгөөний хяналт, хөгжлийн шалгуур үзүүлэлт:

Дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд орчны гол нөлөөлөх хүчин зүйлс болох нөөцүүдийн төлөв байдал, төсвийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй

зэргийг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр зохицуулах, хэрэгжилтийн явцыг үнэлэх хяналтын механизм зайлшгүй шаардлагатай байдаг. Иймээс нарийвчилсан жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан, мөрдөн ажиллаж, биелэлтийг тухай бүр тайлагнах нь чухал юм.



- **Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо**

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтолцоо-д суурилсан PDCA зарчмаар хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг эш үндсэн болгож, үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүрэх үр дүн болон санхүүгийн эх үүсвэр, төлөвлөлтийн үр дүнтэй харьцуулалт хийх байдлаар гүйцэтгэнэ. **Үүнд:**

Явцын хяналт, шинжилгээ: Салбар нь тус бүр жилийн ажлын төлөвлөгөөг хөгжлийн зорилт, стратегитэй уялдуулан төлөвлөөд, үр дүнг үнэлгээг үйл ажиллагааны жилийн тайлангийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгож, захиргааны зөвлөлөөрөө хэлэлцүүлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, стратегийн хэрэгжилтийн явцыг тухайн асуудал хариуцсан албан тушаалтан тус бүр хянаж биелэлтийг нарийвчлан гаргаж, дараагийн төлөвлөлтөнд тооцон хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөт хяналт, шинжилгээ: Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг 2023, 2024 онуудад аймгийн ЗД-ын зөвлөлийн хурлаар дүгнэн хэлэлцэж, стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулна.

Нэгдсэн хяналт, шинжилгээ: Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг нэгдсэн байдлаар 2024 онд дараагийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах урьдач нөхцөлийн цогц шинжилгээ хэлбэрээр хийнэ.